



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/85

Баянтал сум

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3 (гурав) нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдөр зарлаж, төслийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ажлыг газрын биржийн цахим системээр зохион байгуулахыг Газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Энхзул)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Хишигням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАЯР

Сумын Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 11 -ны өдрийн А/85
дугаар захирамжийн хавсралт

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

| № | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Эзэмшүүлэх газрын байршил | Хэмжээ м.кв (га) | Зориулалт | Эзэмшүүлэх хугацаа |
|---|-----------------------------------|------------------------------|------------------|--------------------------------------|--------------------|
| 1 | 4092190 | 16-р зөрлөгийн зүүн урд талд | 5 | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт | 15 жил |
| 2 | 4106379 | Цэргийн ангийн зүүн талд | 5 | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт | 15 жил |
| 3 | 4110976 | 16-р зөрлөгөөс зүүн урагш | 0,3 | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт | 15 жил |

--- ооо ---